



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 8/18

Улаанбаатар хот

Ээлжийн амралт олгох,  
ээлжийн амралтын хугацааг ажилласан  
хугацаанд тооцож үндсэн цалин,  
нэмэгдлийг олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Алтан-Очирын ээлжийн амралтыг 2016 оны 02 дугаар сарын 08-ний өдрөөс 2016 оны 03 дугаар сарын 08-ний өдрийг хүртэл ажлын 18 өдрөөр олгосугай.

2. Аж үйлдвэрийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хооронд хамтран ажиллах санамж бичгийн 2016 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас байгууллагын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээний дагуу 2016 оны үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийн хүрээнд гүйцэтгэл сайжруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлын зайлшгүй шаардлага гарсан тул Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Алтан-Очиртой тохиролцсоны үндсэн дээр 2016 оны 02 дугаар сарын 08-аас 2016 оны 03 дугаар сарын 08-ийг хүртэлх ээлжийн амралтын хугацаанд ажиллуулсугай.

3. Б.Алтан-Очирт ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй хугацааг ажилласан хугацаанд тооцож үндсэн цалин, нэмэгдлийг олгосугай.

4. Үндсэн цалин, нэмэгдлийг холбогдох зардлаас гаргахыг Нягтлан бодогч Г.Батнямд зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Нямхүүд даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

3150600027